

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн халамжийн тухай хуулийн  
Шинэчилсэн найруулгын төслийн тухай*

### Удиртгал

Монгол Улсын нийгэм хангамжийн тогтолцоо нь өнө эртний түүхэн уламжлалтай бөгөөд нийгмийн хөгжлийн үе шатуудад өөрийн онцлогтой, тасралтгүй хөгжсөөр ирсэн билээ.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед нийгэм хангамжийн социалист тогтолцоо- нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тогтолцооны эрхзүйн орчин бүрдэж, нэгдмэл агуулгатай байв. Эдийн засгийн шинэ харилцаанд шилжсэний дараа 1995 онд Нийгмийн халамжийн анхны бие даасан хууль болон Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай, Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийг УИХ-аас батлан, нийгмийн халамжийн бие даасан тогтолцоо бүрдэх эрх зүйн орчин бүрдсэн.

Нийгмийн халамжийн хуулийг 1998, 2005, 2012 онд шинэчлэн найруулж, 2000, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд, Ахмад настны тухай хууль, Алдар цолтой ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулиудыг 2017 онд шинэчилсэн найруулгаар тус тус баталсан. Одоогоор Монгол Улсад нийгмийн халамжийн чиглэлийн 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Эдгээр хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын тогтоол 6, Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан 10 орчим журам, дүрэм болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон бусад сайдын хамтарсан тушаалаар 15 орчим журам, шалгуур, аргачлал хэрэгжиж байна. Хуулийг дагаж гарах журам дүрмийн тоо нь одоогийн журам дүрмийн тооноос 2 дахин багасах бөгөөд журмын нэлээд одоо мөрдөж байгаа журмын олон заалтыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан юм.

Нийгмийн халамжийн бие даасан тогтолцоо бүрдсэн өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд хууль эрх зүйн орчин бүрдэхээс гадна улсын хэмжээнд үйлчилгээг хүргэх байгууллага, хүний нөөцийн тогтолцоо бүрдсэн, хүн амын эмзэг бүлгүүдэд тусламж, дэмжлэг үзүүлж хэвшсэн, төр засгаас боломжийн төсөв, хөрөнгийг төсөвлөдөг зэргээр ахиц, дэвшил гарсан байна.

Нийгмийн харилцааны хөгжил, хурдацтай өөрчлөгдөж буй улс орны нийгэм, эдийн засгийн байдалтай уялдуулан нийгмийн хамгааллын салбарын хууль, эрх зүйн хүрээнд дахин нягталж зохицуулах шаардлагатай тодорхой асуудлууд байна.

Одоогийн нийгмийн халамжийн олон хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлж буй систем нь хөтөлбөрийн үр дүнг харуулахуйцаар сайн хэрэгжиж чадахгүй байгаа бөгөөд ялангуяа халамжийн тогтолцоонд тулгамдаж буй гол асуудлын нэг нь халамжийн хамрах хүрээ хэт өргөн ядуу зорилтот бүлэгт чиглээгүй явдал юм. Өөрөө хэлбэл одоогийн халамжийн тогтолцоо нь өнчин хүүхэд, ганц бие өрх толгойлсон эхчүүд, олон хүүхэдтэй гэр бүл, тэтгэврийн насны харж хандах хүнгүй ахмадууд зэрэг хүн амын олон бүлэгт илүү чиглэсэн, харин амьжиргааны түвшнийг нь харгалзсан,

хамгийн ядуу, орлого багатай тэр хэсэгт чиглэсэн хөтөлбөр хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнээс өөр байхгүй байна. Тиймдээ ч нийгмийн халамжийн хамрах хүрээ хэт өргөн буюу жилд дунджаар 800 орчим мянган хүнийг хамруулж, 4 хүн тутмын нэгд төрөөс тусламж, дэмжлэг үзүүлж байгаа нь зорилтот бүлэгт чиглээгүй нийтлэгээр олгож байгааг харуулж байна.

Тухайлбал, Нийгмийн халамжийн нийт зардлын 55 орчим хувь нь хүн амын хамгийн бага амьжиргаатай 40 хувьд, харин халамжийн зардлын 26 хувь нь хүн амын хамгийн амьжиргаа сайтай 40 хувьд зарцуулагдсан байна.<sup>1</sup> Энэ нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд халамжид хамрагдах зорилтот бүлгийг сонгохдоо өрхийн амьжиргааны түвшинд сууриллаагүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэх зэрэг хүн амын бүлэгт чиглэсэнтэй холбоотой.

Тиймээс нийгмийн халамжийн тогтолцоог улам боловсронгуй болгож, үр ашигтай хэлбэрээр хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Ялангуяа нийгмийн халамжийн олон хөтөлбөр, арга хэмжээг нийгмийн халамжийг дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот буюу эмзэг бүлгийн өрх, иргэнд чиглүүлэх, халамжийн болон нийгмийн ажлын үйлчилгээг илүү хөгжүүлж сайжруулж хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах замаар халамж хүртэгчийг сургах, чадавхжуулах, хөгжүүлэх, ажлын байранд бэлтгэх, ажилтай, орлоготой болгох чиг хандлагыг нэвтрүүлэх шаардлагатай болж байна.

Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 2017 оноос эхлэн боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, олон улсын байгууллагын зөвлөхүүдийн санал, зөвлөмжийн дагуу төслийг сайжруулан ажиллаж байна.

2024 онд гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, нийгмийн баталгааг дээшлүүлэх, гэр бүлийн гишүүдийн хөгжих таатай орчин бий болгох зэрэг салбарын бодлого зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг байгуулсан.

Энэ хүрээнд халамжийн салбарын үйл ажиллагааны өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бодлого, үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах ажлыг салбарын мэргэжилтнүүдээс гадна нийгмийн бодлого, нийгмийн ажлын чиглэлээр ажилладаг эрдэмтэн багш, судлаачдын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.

Дээрх дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан халамжийн бодлогын шинэчлэлийг тодорхойлж, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, ядуурлыг бууруулах, халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчлэх ажлыг эрчимжүүлж Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслүүд, холбогдох бусад судалгаа, баримт бичгүүдийг боловсруулсан юм.

---

<sup>1</sup> “Монгол улсын нийгмийн халамжийн систем: Зардлын хуваарилалт, халамж хүртэгчдийн төлөв байдал” 2019 он, Эрдэм партнерс ХХК

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 9 бүлэг, 38 зүйлтэй байна. Хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан дор танилцуулъя.

### **Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл**

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Энэ хуулийн зорилго нь амьжиргааны түвшин доогуур, эмзэг байдалд өртсөн өрх, иргэний амьжиргааг дэмжих, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, бие даан амьдрах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлсон.

Одоогийн нийгмийн халамжийн тэтгэмж, тусламжийн зорилго нь ядуурал, эмзэг байдалд өртсөн иргэдэд мөнгөн тэтгэмж олгох зохицуулалт давамгайлсан, халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох зарчмыг нэвтрүүлээгүй, халамжийн ба хөдөлмөр эрхлэлтийн бодлого тус тусдаа хэрэгжиж байна. Тиймээс хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилго нь эмзэг, ядуу байдалд өртсөн хэсгийн амьжиргааг дэмжихээс гадна түүнд өртөхөөс урьдчилан сэргийлэх, түүнчлэн хөдөлмөрлөх чадвартай халамж хүртэгч өрх, иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өөрсдийнх нь нөөц, чадварыг дайчилж, ажилтай, орлоготой болгох, бие даан амьдрах чадварыг дэмжих юм гэж үзсэн.

Нийгмийн халамжид ямар бүлгүүдийг хамруулах, яагаад хамруулах шаардлагатай, ямар арга хэрэгсэл ашиглах зэргийг тодорхойлох нь томоохон сорилт байдаг. Зорилтот бүлгийг тодорхойлох гол зорилго нь тухайн тэтгэмжийг хамгийн их хэрэгцээтэй байгаа бүлэгт чиглүүлэх явдал юм.

Засгийн газрын зүгээс төрийн бүхий л байгууллагуудын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрд цугларсан их өгөгдлийг төрийн бодлого шийдвэрт ашиглах, төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлж эхэлсэн. Тиймээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зорилтот бүлгийг тодорхойлоход ашиглаж байгаа "Орлогыг орлуулан тооцох аргачлал"-ыг төрийн мэдээллийн сангуудаас тухайн өрх, иргэний орлогыг орлуулан тооцох боломжтой, өрхийн амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц шаардлагатай мэдээллийг авч ашиглаж болохоор шинэчилсэн бөгөөд цаашид улам сайжруулж ажиллах юм.

Тиймээс манай улсын хувьд энэ аргачлалыг ашиглаж нийгмийн халамж шаардлагатай зорилтот бүлгийг тодорхойлж хөтөлбөрүүдэд хамруулах нь илүү бодитой юм. Үүнтэй холбоотойгоор "нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэн" гэж өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрх, иргэнийг, “босго шугам” гэж нийгмийн халамжийн тухайн арга хэмжээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлох зорилгоор өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийг амьжиргааны түшингээр эрэмбэлсэн өрхөөс нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон онооны хязгаарыг хэлнэ.” гэсэн тодорхойлолтууд тусгасан.

Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлд тусгасан хөтөлбөрүүдийг ихэнхдээ /хүн амын бүлгээр зайлшгүй хамрагдах шаардлагатай зарим тэтгэвэр, тэтгэмжийг эс тооцвол/ нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэн буюу ядуу өрх, иргэнд илүү чиглүүлсэн.

Нийгмийн халамж шаардлагатай зорилтот өрх, иргэн гэсэн нэр томьёог хуулийн төсөлд шинээр тусгасан бөгөөд хуулийн төслийн 4.1.3-4.1.9-д заасан болон нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг гэж тусгасан. Ингэхдээ нийгмийн халамжийн тухайн хөтөлбөрийн онцлогоос шалтгаалж дээрх зорилтот өрх, иргэний амьжиргааны түвшнийг харгалзан хөтөлбөрүүдэд хамрагдахаар шалгуур, нөхцөлийг тус бүрд тодорхойлж өгсөн. Тухайлбал, асаргааны тэтгэмжид байнгын асаргаа шаардлагатай ахмад настны тэтгэмжийг зөвхөн ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай өрхийн ахмад хамрагдахаар тусгасан.

Нийгмийн халамжийн арга хэмжээ, нийгмийн халамжийн үйл ажиллагаа гэсэн 2 нэр томьёо шинээр тусгасан. Учир нь нийгмийн халамжийн ерөнхий үйл ажиллагааг хэлэхдээ үйл ажиллагаа, арга хэмжээ, үйлчилгээ гэх зэргээр янз бүрээр нэрлэж байгаа тул ялгаатай байдлыг илүү тодорхойлж өгсөн.

Арга хэмжээ гэдгийг халамжийн төрөл талаас нь “**нийгмийн халамж**” гэж зорилтот өрх, иргэнд төрөөс **тэтгэмж** олгох, **дэмжлэг, үйлчилгээ** үзүүлэх арга хэмжээг хэлнэ гэж тодорхойлсон.

Үйл ажиллагаа гэдгийг халамжийн байгууллагаас зорилтот өрх, иргэнийг халамжид хамруулахын тулд тэдний олж илрүүлэхээс эхлээд халамжид хамруулаад мэдээллийг нь бүртгэлжүүлэх хүртэлх үзүүлж байгаа бүхий л үйл ажиллагааг хамруулж “**нийгмийн халамжийн үйл ажиллагаа**” гэж зорилтот өрх, иргэнийг нийгмийн халамжийн арга хэмжээнд хамруулах, зохицуулах, мэдээллийн сан бүрдүүлэн ашиглах, хяналт тавих үйл явцыг хэлнэ гэж тодорхойлсон.

### **Нийгмийн халамжийн зарчмууд:**

Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд оролцогчдын баримтлах зарчмын асуудлыг шинээр хуулийн төсөлд тусгасан.

Нийгмийн халамжийн байгууллага, ажилтан хуулийг хэрэгжүүлэхдээ зорилтот өрх, иргэнийг хувь хүний халдашгүй байдлыг хүндэтгэж, хүнлэг ёс зүйтэй харилцааг эрхэмлэх ёстой. Нийгмийн халамж нь зорилтот өрх, иргэний амьдралд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгаж амьдралын чанарт нь эерэг өөрчлөлт гаргахад чиглэгдсэн арга хэмжээг үзүүлдэг, өөрөө өөрсдийнхөө амьдралыг авч явах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх шаардлагыг бий болгох үүднээс хуулийн шинэчлэлд дараах зарчмыг тусгасан байна.

- 1.хүний эрхийг дээдлэх, хувь хүний нэр төрд хүндэтгэлтэй хандах;
- 2.хүмүүнлэг, энэрэнгүй байдлыг эрхэмлэх;
- 3.хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг хадгалах;
- 4.хувь хүний ялгаатай байдал, онцлогийг хүндэтгэх;
- 5.жендерийн эрх тэгш байдлыг хангах;
- 6.улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;
- 7.гэр бүл, орон нутаг, олон нийтийн оролцоог дэмжих;
- 8.үйлчилгээг үл тулгах, сайн дурын үндсэн дээр сонголттой байх;
- 9.нийгмийн халамжийн арга хэмжээ нь нөхцөл шалгуур, хугацаатай

байх;

10.хөдөлмөр эрхлэхийг дэмжих, ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдлыг бууруулах.

Хуулийн төсөлд нийгмийн халамжийн арга хэмжээ нь нийгмийн халамжийн тэтгэмж, нийгмийн халамжийн дэмжлэг, нийгмийн халамжийн үйлчилгээ гэсэн 3 төрөлтэй байхаар тусгасан.

### **Хоёрдугаар бүлэг.Нийгмийн халамжийн тэтгэмж**

Нийгмийн халамжийн тэтгэвэр нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилготой арга хэмжээ юм. Нийгмийн халамжийн тэтгэврийн нэрийг амьжиргааг дэмжих тэтгэмж болгон хуулийн төсөлд өөрчлөн тусгасан. Шимтгэлд суурилагагүй тэтгэмж бөгөөд улсаас олгож байгаа энэ тэтгэмжийг тэтгэвэр гэж нэрлэх нь нийгмийн даатгалын тэтгэвэр шиг ойлгогдох тал байдаг тул нэрийг өөрчилсөн.

Иймд одоо мөрдөж байгаа хуульд заасан нийгмийн халамжийн тэтгэврийг амьжиргааг дэмжих тэтгэмж болгон өөрчилж, өрх толгойлсон эх, эцгийн тэтгэврийг 0-18 хүртэлх насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжтэй нэгтгэсэн. Түүнчлэн 18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийг хамруулахаар нэмж тусгасан. Амьжиргааг дэмжих тэтгэмжийн хэмжээ нь нийгмийн даатгалын шимтгэлийг удаан хугацаанд төлсөн иргэдийнхээс ялгаатай бага байх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэртэй давхцахгүй, тэтгэврийн төрөл хоорондоо мөн адил давхцахгүй байх зарчмыг баримталсан.

Амьжиргааг дэмжих тэтгэмжийн хэмжээг тооцохдоо ахмад настанд өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа, үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэдтэй өрхөд хүүхдийн тоо, өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан тэтгэмжийн хэмжээг тус тус ялгаатай тогтоохоор хуулийн төсөлд тусгасан.

Асаргааны тэтгэмж, одоо мөрдөж байгаа хуулийн хүрээнд олгож байгаа амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг нэгтгэсэн. Ингэснээр одоогийн хуулиар байнгын асаргаа шаардлагатай иргэнд сар бүр олгож байгаа тэтгэмж, улирлын тэтгэмжийн хүрээнд нэг өрхөд очиж байсан зардал буурахгүй бөгөөд цаашид нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд тухай бүр нэмэгдэх боломжтой болох юм. Энэ бүлэгт тэтгэмжийн хэмжээ, олгох, зогсоохтой холбоотой журмаар зохицуулж байсан нарийвчилсан зохицуулалтыг хуульд тусгасан.

Тухайлбал, 16 хүртэлх насны хүүхдэд олгох халамжийн тэтгэмжийг эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгох бөгөөд хүүхэд 16 насанд хүрсэн бол өөрт нь олгох, асрамжийн газарт амьдарч байгаа иргэн болон хүндэтгэсэн үзэх шалтгаанаар тэтгэмжээ 1 жил хүртэл хугацаанд аваагүй иргэний тэтгэмжийг хэрхэн олгох зэрэг зохицуулалтыг нэмсэн.

Халамж авах шаардлага хангасан иргэн, өрх нь тусламж, үйлчилгээнээс өөрийн хэрэгцээ шаардлагадаа нийцүүлэн сонголт хийх боломж олгох зарим

зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан асаргааны тэтгэмж эсхүл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.2-т заасан хувийн туслах үйлчилгээний аль нэгийг сонгох боломжийг бүрдүүлсэн.

Одоогийн хуульд тэтгэмжийн хэмжээ ижил байгааг өөрчилж, зорилтот бүлгийн онцлог нөхцөл байдал, өрхийн бүтэц, ам бүлийн тооноос шалтгаалаад хэмжээг ялгамжтай болгох, тэдгээрийн амьдралын наад захын хэрэгцээг хангах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түшингийн хэмжээ, хэрэглээний үнийн индексийн өөрчлөлттэй уялдуулан амьжиргааг хангах хэмжээнд нэмэгдүүлж байх зохицуулалтууд тусгаад байна.

### **Гуравдугаар бүлэг.Нийгмийн халамжийн дэмжлэг**

Нийгмийн наад захын суурь үйлчилгээ эрүүл мэнд боловсролын мөнгөн бус тусламжийн хөтөлбөрүүд тээвэр болон бусад нийтийн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх хөтөлбөрүүд нь нийгмийн халамжийн бүрэлдэхүүн хэсэгт зайлшгүй байдаг. Одоогийн хуульд байгаа эдгээр арга хэмжээг илүү сайжруулан хуулийн шинэчлэлд тусгасан.

Нийгмийн халамжийн дэмжлэг гэсэн төрөлд хүнс, боловсрол буюу суралцагчийн дэмжлэг, эрүүл мэнд, орон сууц, түлшний үнийн, эрчим хүчний төлбөрийн болон усны үйлчилгээний төлбөрийн дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгав.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 2012 оноос хэрэгжиж байгаа бөгөөд энэ хугацаанд ядуу өрхүүд тогтмол авч байсан. Шинэ хуулийн төсөлд тодорхой шалгуур нөхцөлүүд нэмж, хугацаатай болгосон. Өөрөөр хэлбэл эрүүл мэнд боловсрол, хөдөлмөрийн шалгуур нөхцөлийг биелүүлсэн тохиолдолд хүнсний дэмжлэг авах, зогсоох эсэх нь шийдвэрлэх юм. Хугацааны хувьд 24 хүртэл сар хамрагдаад дахин нэг удаа сунгах, ингэхдээ хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйлчилгээнд хэр идэвх оролцоотой хамрагдсанаас хамаарч сунгахаар зохицуулсан. Мөн амьжиргааг дэмжих, ядуурлаас гаргах урт хугацааны үйлчилгээтэй уялдуулсан. Мөн энэ үйлчилгээнд хамрагдах шаардлагатай боловч шилжин ирсэн, бичиг баримтын зөрчлөөс шалтгаалан сум, хороондоо бүртгүүлж чадаагүй өрх, иргэнийг хамруулах зорилгоор шинээр заалт нэмсэн.

Ядуу өрхийг үе дамжсан ядуурлаас сэргийлэхийн тулд бүх улс орон ядуу өрхийн хүүхдийн хөгжил боловсролд хамгийн их анхаардаг. Боловсролыг дэмжих шинэ хөтөлбөрүүдийг зорилтот бүлгийн хүүхдүүдэд чиглүүлснээр хөрөнгө санхүүг хэмнэж төсвийн үр ашигтай зарцуулалт болно. Өндөр хөгжилтэй орнууд /Япон, АНУ, Австрали/ хүртэл боловсролыг дэмжих үйлчилгээний хүрээнд төрөөс үзүүлэх хөнгөлөлтийг амьжиргааны түвшинтэй уялдуулан зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлдэг. Магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагад суралцахын өмнөх 2-оос доошгүй жилийн хугацаанд асрамжийн газарт асруулж байсан суралцагч, 18 насанд хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны суралцагчид амьжиргааны зардлын дэмжлэг үзүүлэхээр тусгасан.

Одоогийн хуулиар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцаж байгаа боловч тэдгээр иргэд түүний үр шимийг хүртэж чадахгүй байна. Эмзэг бүлгийн

өрхийн архины хамааралтай гишүүнээс шалтгаалсан гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил нийгэмд ихсэж байна. Хэдийгээр эдгээр өрх, иргэдийг чадавхжуулах, хөдөлмөр эрхлүүлэх чиглэлийн үйлчилгээг энэ хуульд шинээр бий болгож байгаа ч архины хамааралтай гишүүдийг эмчлэхгүйгээр тэдгээр өрхтэй ажиллахад үр дүн төдийлөн гарахгүй.

Түүнчлэн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд архины донтолтыг бууруулах эмчилгээ байдаг боловч ихэнхдээ төлбөртэй байдаг учраас ар гэр нь боломжтой иргэд төлбөрөө төлж хамрагддаг байна. Мөн эм нь өндөр үнэтэй учраас авах боломж бололцоо эмзэг бүлгийн өрхийн хувьд боломжгүй юм. Тиймээс эмзэг бүлгийн өрхийн архины хамааралтай иргэний эмийн хөнгөлөлт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр тусгасан.

Мөн өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрхийн ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж, эсхүл түлш худалдан авах эрхийн бичиг хэлбэрээр олгоно.

Эрчим хүчний төлбөрийн дэмжлэгийг өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрх эсхүл байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхөд Эрчим хүчний тухай хуулийн 9.1.4-т заасан аргачлалаар тогтоосон тарифын дагуу, усны үйлчилгээний төлбөрийн дэмжлэгийг өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрхөд тус тус үзүүлэхээр тусгасан.

Нэг өрхөд үзүүлэх халамжийн үйлчилгээний давхардлыг арилгах зорилгоор тухайн өрхөд улсын төсвөөс болон нийгмийн халамжийн сангаас сард олгож байгаа халамжийн тэтгэмж, дэмжлэгийн нийлбэр, өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүний тоо зэргээс хамаарч халамжийн тэтгэмжийн хэмжээг бууруулж тооцож болохоор тусгасан.

Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг түүний нөхцөл, шалгуур, хугацаатай холбоотой харилцааг тусгасан. Зорилтот өрхийн хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх бодлогыг халамжийн хөтөлбөрүүдтэй уялдуулах, хүн капиталд хөрөнгө оруулах, үе дамжсан ядуурлаас сэргийлэх бодлого тусгасан.

### **Дөрөвдүгээр бүлэг.Нийгмийн халамжийн үйлчилгээ**

Нийгмийн халамжийн үйлчилгээг 4 төрөлтэй байхаар тусгасан.

- 1.бие даан амьдрах чадавхыг дэмжих цогц үйлчилгээ;
- 2.кейс менежментэд суурилсан нийгмийн халамжийн үйлчилгээ;
- 3.асрамжийн үйлчилгээ;
- 4.гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ.

Нийгмийн халамжийн хөтөлбөрийг ихэнхдээ төрийн байгууллагаас хэрэгжүүлдэг хэдий ч зарим тохиолдолд төрийн байгууллагын өмнөөс хувь хүмүүс, төрийн бус байгууллага, хувийн хэвшил гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг. Ялангуяа нийгмийн үйлчилгээг хувийн хэвшлээр гэрээлэн гүйцэтгэх явдал түгээмэл байдаг.

Одоогийн хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн халамжийн нийт хөтөлбөрүүдийн дийлэнх буюу 90 гаруй хувь нь бэлэн мөнгөний хөтөлбөрүүд, төрийн бус байгууллагаар гэрээлэн зорилтот бүлгийн хөгжлийг дэмжих үйлчилгээг халамжийн зардлын 1 хүрэхгүй хувийг зарцуулж байна. Бусад улсад бэлэн мөнгөний болон хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлын харьцаа 50:50 хувь байдаг.

Одоогийн хуульд заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 2008 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Уг үйлчилгээг хэрэгжүүлэхэд явцад иргэн, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж, зорилтот бүлгүүдийн нийгмийн оролцоо дээшилсэн боловч аймаг, орон нутагт төрийн бус байгууллагын тоо бага, чадавх сул, үйлчилгээний чанарт хяналт дутмаг байгаагаас үйлчилгээ улсын хэмжээнд жигд хэрэгжихгүй, төсөв хөрөнгө багассаар жилдээ 1 тэрбум гаруй төгрөг зарцуулж байна. Гэсэн ч уг үйлчилгээнд хамрагдах иргэдийн хэрэгцээ, шаардлага нэмэгдэж байгаа тул үйлчилгээний чанарыг сайжруулж олон улсын жишиг, мэргэжлийн түвшинд хүргэх, үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Вьетнам, Филиппин ядуурлаа бууруулахад бага мөнгөөр чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ хөтөлбөр хэрэгжүүлдэг. Дэлхийн улс орнууд ядуурлыг бууруулах нь богино хугацааны арга хэмжээ биш, урт хугацааны амьжиргааг дэмжих үйлчилгээ юм гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Тиймээс зорилтот бүлгийн иргэд, өрхүүдэд зөвхөн мөнгөн тусламж үзүүлдэг хэт нэг талыг барьсан бодлогоос татгалзаж, хуулийн төсөлд нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдийг чадавхжуулах, тэдний хэрэгцээнд нийцсэн шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан. Тухайлбал, Зорилтот өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах, бусад үйлчилгээнд холбон зуучлах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх зэргээр тухайн өрхийг чадавхжуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Энэ үйлчилгээг эмзэг хэсэгт чиглүүлж тэдний зан үйл хандлагыг өөрчлөх, нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, ажилтай орлоготой болоход чиглэсэн үйлчилгээг мэргэжлийн төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэхээр тусгав. Мөн тэдгээр өрх иргэнтэй ажиллахад орон нутгийн байгууллага иргэний үүрэг оролцоог тодорхойлж өгөв. Нийгмийн ажилтнууд эмзэг бүлгийн айл, өрхөөрөө тойрч асуудлыг нь олж шийдвэрлэж нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээгээ үзүүлэхээр зохицуулсан.

Мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласнаар үйлчилгээний чанар, халамжийн зардлын үр нөлөө сайжирч, төрийн төвлөрсөн үйлчилгээний төвлөрөл багасна, нөгөө талаар төрийн бус байгууллагууд чадавхижж, мэргэжлийн ажилтнуудын ажлын байр нэмэгдэх давуу талтай юм.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-д заасан хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж амьжиргааны эх үүсвэрээ алдсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд учирсан хохирол,

хэрэгцээний үнэлгээнд үндэслэн **Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ** үзүүлэхээр шинээр нэмсэн.

Асаргааны хувилбарт үйлчилгээг түр эсхүл урт хугацаагаар, өдрөөр болон явуулын хэлбэрээр төлбөртэй үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, хувийн хэвшлийн байгууллага асрамжийн үйлчилгээ эрхлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, хувьсах зардал олгох зэргээр сайжруулсан. Түүнчлэн нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний улсын асрамжийн газар байгуулах асуудлыг Засгийн газар, бүсийн болон орон нутгийн асрамжийн газар байгуулах асуудлыг тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх зохицуулалт бүрдүүлсэн.

Мөн сэтгэцийн өвчтэй хүний асрамжийн газар асруулж байгаа асруулагчийн зардлыг Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд зөвхөн Эрүүл мэндийн байгууллага хариуцах байгаад өөрчлөлт оруулж сэтгэцийн тусгай төрөлжсөн асрамжийн газар асруулж байгаа асруулагчийн хоол, хувцас, ахуйн хэрэгцээний зардлыг норм, нормативын дагуу Нийгмийн халамжийн сангаас зарцуулахаар тусгасан. Сэтгэцийн өвчтэй хүн нь Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу өөртөө болон бусдад гэм хор учруулах эрсдэлтэй байдаг тул бие даасан хамгаалалт шаардлагатайг тусгасан байдаг. Одоо зарим ахмадын газарт сэтгэцийн өвчтэй хүн асруулж байгаагаас шалтгаалан бусад асруулагчийн аюулгүй байдалд хүндрэл үүсэж, тайван асруулах боломжгүй, сэтгэл зүйн хувьд айдас, дарамттай болсон талаар асрамжийн газруудаас бичгээр болон бусад байдлаар олон санал гомдол ирж байна. Харин сэтгэцийн эмгэг биш оюуны хөгжлийн бэрхшээлтэй буюу тархины саажилт, аутизм, даун, унаж татах гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн асрамжид асруулж байгаа болно. Иймд Сэтгэцийн өвчтэй хүний бие даасан төрөлжсөн асрамжийн байгууллага яаралтай байгуулах, үйлчилгээг эрүүл мэндийн болон халамжийн байгууллага хамтран үзүүлэх шаардлагатай байгаа тул энэ асуудлыг шийдвэрлэхээр тодорхой заалтуудыг хуулийн төсөлд тусгасан.

### **Тавдугаар бүлэг.Нийгмийн халамжийн сан**

Энэ бүлгийн зохицуулалт үндсэндээ өөрчлөлтгүй бөгөөд сангийн орлого, зарлагын мэдээ, тайланг гаргах хугацааг бусад хууль тогтоомжид заасан хугацаатай уялдуулан өөрчилсөн.

Түүнчлэн Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн халамжийн сангийн жилийн эцсийн нэгдсэн тайланг хянан төрийн аудитын байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах, халамжийн сангийн мэдээ, тайлангийн маягтын загварыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах зохицуулалтыг шинээр нэмсэн болно.

### **Зургадугаар бүлэг.Нийгмийн халамжийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт**

Хуулийн төслийн 6 дугаар бүлэгт нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, төрийн захиргааны болон аймаг, нийслэл, дүүргийн халамжийн байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтны эрх, үүргийг, мөн хуулийн 34 дүгээр зүйлд бүх шатны Засаг дарга нарын эрх, үүргийг тодорхой зааж өгсөн болно.

Улсын хэмжээнд нийт 600 гаруй халамжийн нийгмийн ажилтнууд ажиллаж байгаагаас 50 орчим хувь нь нийгмийн ажилтны бакалавр болон магистр зэрэгтэй байна. Иймд олон улсын жишгээр сум, хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст зөвхөн нийгмийн ажлын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй хүмүүсийг ажиллуулах хуулийн зохицуулалтыг бүрдүүлсэн. Ингэхдээ одоо ажиллаж байгаа ажилтнуудын эрхийг хөндөхгүйгээр шинээр ажиллах ажилтнуудад энэхүү мэргэжлийн шаардлагыг тавьсан.

Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлээр нийгмийн халамжийн бэлэн мөнгөний хөтөлбөрийг багасгаж, өрх, иргэнийг чадавхжуулах халамжийн болон нийгмийн ажлыг нэмэгдүүлж байгаа нөгөө талаас халамжийн цахимжуулалттай холбогдуулан нийгмийн ажилтны өрөө тасалгаандаа суух бичиг цаасны ажил багасах тул халамж шаардлагатай зорилтот өрх, иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, өрхөөр явж газар дээр нь нөхцөл байдлын үнэлгээ хийх, тэдний нөөц боломжийг үнэлэх, нийгмийн амьдралд оролцоход нь туслан, дэмжих, төрийн бусад үйлчилгээнд холбон зуучлах, идэвхжүүлэх зэрэг нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх үүргийг уг хуулийн төсөлд нэмэгдүүлсэн.

Халамжийн нийгмийн ажилтнуудын хувьд хүнд нөхцөлд амьдардаг, зан үйл харилцаа хандлага, ёс зүйн хувьд доголдолтой нийгмийн хамгийн эмзэг бүлгийн өрх, иргэнтэй тулж ажиллах бөгөөд тэдгээр айл өрхийн амьдрал ахуйтай газар дээр нь очиж танилцахад орчны янз бүрийн /архидалт, хүчирхийлэл болон гэрийн тэжээвэр амьтны өртөлт/ эрсдэлт нөхцөл байдал зэргээс шалтгаалаад ажиллах нөхцөл хүнд учраас тэдний нийгмийн баталгааг хангах, нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг зайлшгүй шаардлагатай байдаг.

Энэ талаарх бусад улс орны хууль тогтоомж, туршлагаас харахад тухайлбал, Филиппин улсын хувьд нийгмийн ажилтнуудад төрөөс үзүүлдэг дэмжлэг /цалин, ажилласан хугацаа, илүү цагийн нэмэгдэл г.м/-ээс гадна ажлын онцлог нөхцөлөөс хамаарч тэтгэмж олгодог байна. Үүнд, онцгой байдлын үед яаралтай тусламж үзүүлэх ажилд ажилласан бол дуудлагын цалин олгох, алслагдсан, түгшүүртэй газар, тусгаарлагдсан өртөө, сэтгэцийн эмнэлэг, гамшигт байдал зарласан газруудад томилогдсон нийгмийн ажилтнууд сарын үндсэн цалингийн доод тал нь хорин хувь (20%)-тай тэнцэх хэмжээний аюулын нөхөн олговор олгодог байна. Үүнээс гадна амьжиргаа/тээврийн хэрэгслийн тэтгэмж, орон сууцны дэмжлэг олгож, ажлын гүйцэтгэлийг үнэлгээнээс хамаарч цалингийн нэмэгдэл, албан тушаал ахиулах, мэргэжил дээшлүүлэх сургалтын тэтгэлэг олгох зэргээр нэмэлт нийгмийн баталгааг хангаж өгдөг байна.

Ийм учраас дээр дурдсан онцлог, эрсдэлт нөхцөлд ажиллах шаардлага болон хуулийн төсөлд шинээр орж байгаа нийгмийн халамжийн үйлчилгээний шинэ төрлүүдийг зорилтот өрх, иргэдэд үзүүлэх зэргийг харгалзан цалингийн шатлал сүлжээг нэмэх, ажлын үр дүнгээс хамаарч мөнгөн урамшуулал олгох, мэргэшлийн зэрэг олгож зэргийн нэмэгдэл олгох зэргээр халамжийн нийгмийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зохицуулалтууд тусгалаа.

**Долоодугаар бүлэг. Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны хүлээх үүрэг**

Халамж хүртэгч өрх, иргэний үүрэгтэй холбоотой зохицуулалт хуулийн төсөлд тусгах шаардлагатай гэсэн саналууд халамжийн ажилтнуудаас гарсан бөгөөд ялангуяа хөдөлмөр эрхлэлттэй холбоотой шалгуур нөхцөлийг биелүүлэхгүй байх, тэтгэвэр, тэтгэмж авч байсан гэр бүлийн хүн нь нас барах тохиолдолд мэдэгдэхгүй илүү авах асуудал гардаг. Иймээс хуулийн төсөлд халамжийн арга хэмжээнд хамрагдаж байгаа зорилтот өрх, иргэн болон бусад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүргийг энэ бүлэгт шинээр тусгасан.

Түүнчлэн бүх шатны Засаг дарга орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан нутаг дэвсгэрийнхээ хүрээнд хүлээх үүргийг тодорхой зааж өгсөн. Тухайлбал, нутаг дэвсгэрийн хүн амын хүн амын ядуурал, ажилгүйдлийг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, зорилтот өрх, иргэнийг үнэн зөв тодорхойлж нийгмийн халамжийн болон нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, тэднийг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт тэргүүн ээлжид хамруулах зэрэг арга хэмжээг тусгасан.

### **Наймдугаар бүлэг.Нийгмийн халамжийн мэдээллийн сан**

“Нийгмийн халамжийн нэгдсэн систем” /ehalamj.mn/-ийг 2020 оны 8 дугаар сараас нэвтрүүлэн хөгжүүлж, Нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн. Түүнчлэн Орлогыг орлуулан тооцох аргачлалд суурилсан Монгол Улсын нийт өрхийн амьжиргааны түвшний мэдээллийн сан буу Өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн бодлого, хөтөлбөрт ашиглаж байна.

Энэ бүлэгт дээрх мэдээллийн сан, түүний бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, харилцан мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг тусгасан бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн мэдээллийн сангаас мэдээлэл авах, солилцох, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах зарим зүйл, заалтыг уялдуулан өөрчилсөн.

Нийгмийн халамжийн цахимжуулалтын хүрээнд халамжийн сангийн төсвийг бодитой төлөвлөх, нэг өрхөд олон төрлийн халамжид хамрагдахаар бол аль нэг тэтгэмжийг сонгон хамрагдах эрх олгох зэргээр халамжийг давхардалгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

### **Есдүгээр бүлэг.Бусад зүйл**

Энэ бүлэгт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийх болон хууль тогтоомж зөрчигчид холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх болон хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тусгасан.

Түүнчлэн уг хуулийн шинэчлэлээр хасагдаж байгаа халамжийн зарим хөтөлбөрийн хувьд хамрагдаж байсан иргэдийг тухайн хөтөлбөрт хамрагдах эрхийг дуусах хүртэл хугацаанд хэвээр хадгалах, зөвхөн уг хууль хэрэгжсэнээс хойш шинээр эрх үүсэх иргэдэд хамаарах зэрэг зохицуулалтыг Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуульд тусгасан.

## **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ДАГАЛДУУЛАН БОЛОВСРУУЛСАН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД**

### **1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д "эмнэлгийн хэрэглэгдэхүүн" гэж өвчин эмгэг, гэмтэл согогийг оношлох, эмчлэх, хянах, нөхөн сэргээх, сэргээн засах, сувилах, хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагааг хамгаалах, эд эрхтнийг хиймлээр орлуулах, хүний гадаад төрх байдлыг өөрчлөхөд хэрэглэх зориулалттай нэг удаагийн болон дахин ашиглах боломжтой эмнэлгийн хэрэгслийг" гэж заасан бөгөөд үүнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай протез, ортопедийн хэрэгсэл хамаарч байна.

Иймд хуулийн 21 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэний Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасан өндөр болон зарим дунд эрсдэлтэй эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн хөнгөлөлтийг гурван жил тутамд нэг удаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан жагсаалт, төлбөрийн хэмжээгээр, энэ хуулийн 21.3, 21.4-т заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүний зардлыг жил бүр нийгмийн халамжийн сангаас Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.

Харин эмнэлгийн хэрэглэгдэхүүнээс бусад нэн шаардлагатай туслах хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн зардлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсөвт тусган, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас баталсан жагсаалт, олгох давтамж, жишиг үнийг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хараа, сонсголын бэрхшээлтэй хүнд нөхөн олгохоор хуулийн төсөлд нэмсэн.

Энэ хуулийн 21.1."Хөгжлийн бэрхшээлтэй хүний хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл, авах зардлыг Нийгмийн даатгалын, Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын, Тэтгэмжийн даатгалын, Эрүүл мэндийн даатгалын, Нийгмийн халамжийн сангаас тус тус санхүүжүүлнэ".гэж заасан нь агуулгын хувьд давхцаж байгаа тул "Нийгмийн даатгалын" болон "Тэтгэмжийн даатгалын" гэснийг, мөн нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтөд хамрагдахад шаардагдах үнэмлэхийг хассан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эмч, эмнэлгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн өөрийн бие эрхтний онцлогт тохирсон, чанар, стандартын шаардлагад нийцсэн протез, ортопедийн хэрэгслийг эрүүл мэндийн байгууллагаар хийлгэх, худалдан авах боломжийг бүрдүүлж, санхүүжилт, төсөв хөрөнгийн хяналт, хариуцлагыг сайжруулах зорилгоор нийгмийн халамжийн сангийн төсвийг хамт эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэх болсонтой холбоотой энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4, 26.1.6, 26.1.11, 26.1.14 дэх заалтыг тус тус хүчингүй болгов.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настныг рашаан сувилал, амралт сувилалд хамруулдаг боловч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй буюу байнгын асаргаатай иргэдийг хамруулах рашаан сувиллын тоо хязгаарлагдмал, дэд бүтэц муу, зардал өндөр зэргээс үйлчилгээ авах нь цөөн байна.

Одоо мөрдөж байгаа хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд чиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулахаар заасныг өөрчилж, төрөлжсөн асрамжийн болон энэ хуулийн 26.1.17-д “хувийн туслах үйлчилгээ болон өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах асаргааны хувилбарт үйлчилгээ” заасан үйлчилгээнд хамруулахаар өөрчлөн найруулсан.

Үйлчилгээ үзүүлэх журам, үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална, үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтны цалин хөлс, үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлнэ;

Мөн хуулийн 26.8-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих төвийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлэх зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлнэ.” гэж нэмж тусгаад байна.

Хуулийн 26.1.7, 26.1.9 дэх заалтыг өөрчилснөөр хөгжлийн бэрхшээлтэй хүний сувилуулах сувиллын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, мөн сувилалд ирж, очих унааны зардлын хөнгөлөлт олгохоор хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн 26.1.5-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх гэсний “цэцэрлэг, сургуульд” гэснийг “бүх шатны боловсролын байгууллага, дэмжих төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ болон бусад нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний байгууллагад” гэж өөрчлөн найруулав.

Түүнчлэн хөдөө орон нутгаас аймгийн төв, нийслэл Улаанбаатар хот, хотод бүх шатны боловсролын байгууллагад суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч тус бүрд ирж, очих тээврийн зардлыг жилд нэг удаа автозамын болон агаарын тээврийн тарифт үнээр тооцож олгохоор нэмж тусгав. Нийслэлд смарт карт нэвтрүүлсэнтэй холбоотойгоор хуулийн 32.8.-д хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэлд зориулалтын картаар зорчих, 26.1.16-д хөгжлийн бэрхшээлтэй хүнд зайлшгүй шаардлагатай тохиолдолд живхний үнийг хөнгөлөхөөр, 26.1.12-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийг 50 хувь хөнгөлдөг байсныг 100 хувь болгон нэмж, 37.2.3-т ахмад настны хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг Эрүүл мэндийн тухай хуулийн 16.21-д заасан комисс тогтоохоор өөрчлөн найруулав.

Энэ хуулийн 21.1, 21.2, 21.3, 21.4, 21.5, 21.6, 26.2 дахь хэсэгт болон 26.1.7, 26.1.9, 26.1.13, 26.1.17-д заасан хөнгөлөлт, үйлчилгээг цахимжуулах, давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитой олгох зорилгоор Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглахаар нэмж тусгасан.

## **2. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Дэлхийн улс орнуудад насны үечлэл нь тухайн улс орны хөгжил, нийгэм эдийн засгийн байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөгжил, нийгмийн халамж дэмжлэг, хүн амын дундаж наслалтын байдлаас хамааран ялгаатай байдаг.

Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Энэ хуулийн үйлчлэлд 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн хамаарна” гэж заасан. Харин ихэнх улс орнууд ахмадын насыг 65 наснаас эхлэн тооцдог байна.

Улсын Их Хурлаас 2023 онд шинэчлэн баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг Тайлбар хэсэгт заасан насанд хүрсэн” гэж заасан. Үүнтэй нийцүүлэн Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулж нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсээгүй ахмад настанд нийгмийн халамжийн тэтгэвэр олгох насыг өөрчлөн хуулийн 12.2.-т “Энэ хуулийн 12.1.1-д заасан иргэнд тэтгэвэр олгоход Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насыг баримтална.” болгон 2024 оноос мөрдөж байна.

Иймд ахмадын насыг дээрх хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулах, олон улсын ахмадын нас тогтоож байгаа жишигт нийцүүлэх зорилгоор уг хуулийн үйлчлэлд хамаарах насыг хуулийн төслийн 3.1-д “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Тайлбар хэсэгт заасан насанд хүрсэн” гэж өөрчилсөн.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу ахмад настны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцдагийн хувьд сувиллын газарт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг хариуцаж байна. Иймд нэг төрлийн үйлчилгээнд 2 сангаас давхардуулан санхүүжилт олгохгүй байх зорилгоор Ахмад настны тухай хуулийн 8.1.2-т заасан сувилал, 10.1.2-т заасан магадлан итгэмжлэгдсэн сувиллын үйлчилгээ, хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулах, төсвийг эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэхээр хуулийн 10.3-т “Энэ хуулийн 10.1.2-т заасан сувиллын хөнгөлөлтийн жишиг үнийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.” гэж нэмж, 8.1.2-т заасан “...амралт, сувиллын газарт...” гэснээс сувиллыг хасч “ахмадын зориулалттай амралтын газарт” гэж өөрчилсөн.

Магадлан итгэмжлэгдсэн сувиллын хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгохоор өөрчилсөнтэй уялдуулан 10.1.2 дахь заалтаас нэг талын унааны зардлын хөнгөлөлтийг хасах, хуулийн 7.1.3-т заасан явуулын үйлчилгээ, 7.1.4-т заасан өдрийн үйлчилгээ нь 7.7.10-т заасан асаргааны хувилбарт үйлчилгээний өдрөөр асрах, гэрээр асрах үйлчилгээтэй агуулгын хувьд давхцаж байгаа тул хүчингүй болгох, ишилсэн холбогдох заалтаас хасахаар болно.

Ахмад настны тухай хуулийн 8.1.1-д заасан ахмад настны шүдний протез, харах, сонсох эрхтний ортопедийн хэрэгсэл, бусад нэн шаардлагатай туслах хэрэгслийг тухайн хүний эрүүл мэнд бие эрхтнийг орлуулах, согогийг засах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмчийн дүгнэлтэд үндэслэн протезийн үйлдвэр, шүдний эмнэлэг, хараа, сонсголын эмнэлэг, төвүүд,

эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагаар ихэвчлэн олгож байгаа үйлчилгээ юм. Уг үйлчилгээг холбогдох мэргэжлийн байгууллагаар үзүүлэх, хяналтыг сайжруулах, төсөв хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгоор эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх шаардлагатай байна.

Иймд нийгмийн халамжийн сангийн төсвийн хамт эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж байгаа тул хуулийн төсөлд 8.1.1 дэх заалтын “нийгмийн халамжийн” гэснийг “эрүүл мэндийн” гэж өөрчлөхөөр тусгасан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “сум хорооны халамжийн нийгмийн ажилтан” гэсэнтэй уялдуулан Ахмад настны тухай хуулийн “сум хорооны нийгмийн ажилтан” гэсний нийгмийн ажилтны өмнө “халамжийн” гэж нэмж оруулсан.

Ахмад настны түлш худалдан авах болон орон сууцны үнийн хөнгөлөлт төлөхөд олгох мөнгөн тусламжийг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 12.2-т “Өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрх эсхүл байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхөд нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр түлш олгох арга хэмжээг аймаг, орон нутаг нь журам батлан хэрэгжүүлж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.” гэж дэмжлэгийн нэг төрөл болгон оруулсантай холбогдуулан хасах, магадлан итгэмжлэгдсэн сувиллын хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын сан руу шилжүүлсэнтэй холбоотой сувилалд явах нэг талын зардлын хөнгөлөлтийг хасах, гэрээр асруулж байгаа асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй ахмад настанд олгох мөнгөн тусламж нь асаргааны тэтгэмжтэй давхцаж байгаа тул хасах, хуулийн 7.1.3-т заасан явуулын үйлчилгээ, 7.1.4-т заасан өдрийн үйлчилгээ нь 7.7.10-т заасан асаргааны хувилбарт үйлчилгээний өдрөөр асрах, гэрээр асрах үйлчилгээтэй агуулгын хувьд давхцаж байгаа тул тус тус хасахаар төсөлд тусгасан.

### **3. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, амьжиргааны түвшний доогуур үнэлгээтэй өрхийн 0-6 хүртэлх насны хүүхдэд нэн шаардлагатай эм, бичил тэжээл, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эм, хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг үзүүлэхээр хуулийн төсөлд тусгав.

Түүнчлэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д "эмнэлгийн хэрэглэгдэхүүн" гэж өвчин эмгэг, гэмтэл согогийг оношлох, эмчлэх, хянах, нөхөн сэргээх, сэргээн засах, сувилах, хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагааг хамгаалах, эд эрхтнийг хиймлээр орлуулах, хүний гадаад төрх байдлыг өөрчлөхөд хэрэглэх зориулалттай нэг удаагийн болон дахин ашиглах боломжтой эмнэлгийн хэрэгслийг" гэж заасан бөгөөд үүнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай протез, ортопедийн хэрэгсэл хамаарч байна. Нөгөө талаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн эмч, эмнэлгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн өөрийн бие эрхтний онцлогт тохирсон, чанар, стандартын шаардлагад

нийцсэн протез, ортопедийн хэрэгслийг эрүүл мэндийн байгууллагаар хийлгэх, худалдан авах боломж бүрдэж, санхүүжилт, хяналт сайжирна.

Донорын тухай хуулийн дагуу цусны хүндэт донор, амьд донор иргэнд болон Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу нийгмийн халамжийн сангаас олгодог магадлан итгэмжлэгдсэн сувилал, рашаан сувиллын хөнгөлөлт нь эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийн зардлыг хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэг төрөл тул эрүүл мэндийн даатгалын байгууллагаас хөнгөлөлтийг үзүүлэх боломжтой юм.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, донор иргэний сувиллын хөнгөлөлт, протез, ортопедийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллага руу шилжүүлэн ингэхдээ нэмэлт төлбөрийг нийгмийн халамжийн сангаас эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн төсөвт шилжүүлэн хэрэгжүүлэхээр хуулийн төслийн 9.7-д тусгав.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн 15.1-д согтуурах мансуурах донтой иргэний донтолтыг бууруулах эмийн хөнгөлөлт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төрөлд нэмсэн.

Мөн энэ хуулийн төслийн 15.1-д “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.2.3-т заасны дагуу өрхийн амьжиргааны түвшин нь босго шугамаас доогуур үнэлгээтэй өрхийн албан журмын даатгал төлж байгаагаас бусад гишүүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.” гэж тусгав.

#### **4. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа эдгэшгүй хүнд өвчтэй, хэвтрийн болон байнгын асаргаа шаардлагатай иргэнд тогтмол асаргаа, сувилгаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тэдгээр байгууллагын бүтэц орон тоонд эмч, сэргээн засалт, уламжлалтын сувилалтай, зарим томоохон асрамжийн газрууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сэргээн засах сувиллын үйлчилгээг үзүүлдэг нэгжтэй байна.

Гэвч асрамжийн байгууллагууд нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1-д заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөлд хамаарахгүй байгаа нь зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах боломжгүй нөхцөл байдалтай байна.

Иймд төсөлд Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.10 дахь заалтын “төв” гэсний дараа “ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын дэргэдэх сэргээн засах нэгж”, 29.5 дахь хэсгийн “төвд” гэсний дараа “энэ хуулийн 15.1.15-д заасан нэгжид” гэж тус тус нэмсэн.

Иргэний хөгжлийн бэрхшээлтэй эсэх, байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлдог Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Эмнэлэг хяналтын комиссын гишүүн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд тухайн иргэнийг буруу тогтоосон, хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэрэг хууль бус үйлдэл, ёс зүйн доголдлыг нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага иргэний зүгээс эмнэлгийн мэргэжилтний

болон анагаах ухааны ёс зүйн хороонд гаргах зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж оруулсан.

Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 16.21 дэх хэсэгт Эмнэлэг хяналтын комисс нь ахмад настны байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтоохоос гадна мөн ахмад настны хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлохоор өөрчлөн тусгав. Ингэснээр ахмад настан дээрх хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлуулан хөгжлийн бэрхшээлтэй ахмад настны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгодог шаардлагатай тусламж, хөнгөлөлтөд хамрагдах юм.

## **5. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулж Эрүүл мэндийн тухай хуульд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөлд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд асрамжийн үйлчилгээ болон тэдэнд сэргээн засах, нөхөн сэргээх чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын “сэргээн засах нэгж”-ийг нэмж тусгасан.

Үүнтэй холбоотойгоор Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн “13.3.3.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын дэргэдэх сэргээн засах нэгж.” гэж, мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 19.3.1-д заасан тусгай зөвшөөрлийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад олгох төрөлд “14.2.7. “сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ” гэснийг “сэргээн засах тусламж, үйлчилгээ” гэж өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгав.

## **6. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан.

Бүс нутгийн эдийн засгийн хөгжил иргэдийнх нь аж байдал, амьжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй холбоотой байдаг. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад салбар дундын уялдаатай бодлого, үйл ажиллагааг дэмжиж, зорилтот бүлэг, ядуурлын түвшин өндөр бүс нутаг, аймгуудын иргэдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх, ажлын байрыг хадгалах, шинээр ажлын байр бий болгох замаар иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг ажилтай, орлоготой болгох, төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг зөв, хүртээмжтэй ашиглан зохион байгуулалттайгаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах боломжтой.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч юм.

Иймээс Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журам болон Орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи дан согтуурахтай тэмцэх журам, Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд нийтийн халуун усны үйлчилгээ, усны

үйлчилгээний төлбөрийн дэмжлэг олгох, санхүүжүүлэх журмыг боловсруулан батлуулж хэрэгжүүлэхээр тусгасан.

## **7. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай**

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн хүүхдээ биечлэн асардгаас хувьд дийлэнх тохиолдолд аль нэг нь ажил эрхлэх боломжгүй. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг, эхийн зүгээс нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах хүсэлтийг байнга ирүүлдэг тул “Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.” гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

## **8. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай танилцуулга**

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан Зөрчлийн тухай хуульд дараах агуулгаар нэмэлт оруулахаар хуулийн нэмэлт оруулах төслийг боловсрууллаа.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн үйлдэл, үйл ажиллагааны чадамж, байнгын асаргаа шаардлагатай эсэх, хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг буруу тогтоосон, эсхүл тогтоохгүй байх;
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн бэрхшээлтэй эсэх, байнгын асаргаа шаардлагатай эсэхийг буруу тогтоох эсхүл тогтоохгүй байх;
- Хуурамч баримт бичиг бүрдүүлэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж, зардлыг үндэслэлгүйгээр илүү тогтоолгон авах;
- нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглаж, зарцуулах;
- Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг үндэслэлгүйгээр устгасан, засварласан, хуурамч мэдээлэл оруулсан зэрэг тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан.

## **9. Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай**

Одоогийн мөрдөж байгаа Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам болон амьд донор болон цусаа 35-аас дээш удаа өгсөн донорыг магадлан итгэмжлэгдсэн дотоодын сувилалд жилд нэг удаа Засгийн газраас тогтоосон жишиг үнийн дагуу хөнгөлөлттэй үнээр сувилуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан.

Үүний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/164 дүгээр тушаалаар “Амьд донор болон цусны Хүндэт донорыг сувилуулах журам”-ыг батлан

цусны хүндэт донор болон амьд донорыг рашаан сувилалд үнэ төлбөргүй сувилуулах хөнгөлөлтийг нийгмийн халамжийн сангаас олгож байна.

Рашаан сувиллын үйлчилгээ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг тусламж, үйлчилгээний нэг голлох төрөл юм. Мөн рашаан сувиллуудын магадлан итгэмжлэлийг Эрүүл мэндийн яамнаас олгодог бөгөөд сувиллын шалгуур стандартыг Эрүүл мэндийн яам хариуцан батлуулдаг.

Гэвч рашаан сувиллын байгууллагад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, цусны хүндэт донор иргэн сувилуулахад рашаан сувиллын байгууллагад эрүүл мэндийн даатгалаас болон нийгмийн халамжийн сангаас давхар санхүүжилт олгогдож байна.

Иймд төсөв санхүүжилтийн давхардлыг арилгах зорилгоор донорын рашаан сувиллын хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалын сан руу шилжүүлэх зохицуулалтыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.

Үүнтэй уялдуулан Донорын тухай хуулийн 22.1 дэх хэсэгт “Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам болон амьд донор болон цусаа 35-аас дээш удаа өгсөн донорыг магадлан итгэмжлэгдсэн дотоодын сувилалд жилд нэг удаа Засгийн газраас тогтоосон жишиг үнийн дагуу хөнгөлөлттэй үнээр сувилуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж өөрчлөн найруулав. Ингэснээр донорын рашаан сувилалд сувилуулах холбогдох журмыг Эрүүл мэндийн сайд баталж, эрүүл мэндийн даатгалын байгууллага хөнгөлөлтийг үзүүлэх боломжтой болно.

## **10. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль**

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.” гэж заасан байдаг.

Сэтгэцийн эмгэгтэй хүний эрүүл мэндийн байдал, онцлог хэрэгцээг харгалзан асрамжийн тусламж үйлчилгээг тусад нь төрөлжүүлэн үзүүлэх хэрэгцээ шаардлагатай бөгөөд асруулж байгаа иргэний хоол хүнс, хувцас, зөөлөн эдлэл, эм, живх, ариун цэврийн болон эмнэлгийн туслах хэрэгслийн болон бусад хувьсах зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд дараах байдлаар тусгав.

Хуулийн төслийн “8.3.Сэтгэцийн эмгэгтэй хүний эрүүл мэндийн байдал, онцлог хэрэгцээг харгалзан асрамжийн газрыг төрөлжүүлэн үзүүлэх ба Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.15-д заасан үйлчлүүлэгчийн хувьсах зардлыг нийгмийн халамжийн сангаас тухайн байгууллагад олгоно.” гэсэн хэсэг нэмж оруулсан.

## **11. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль**

Амьжиргаа багатай өрхөд усны төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх зорилгоор Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулав.

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх, уг зардлыг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр орон нутгийн төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгав.

## **12. Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай**

Одоогийн мөрдөж байгаа Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд хувийн хэвшлийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настанд нэмэгдэл олгох зохицуулалт байдаггүй.

Иймд хуулийн төсөлд “8.2. Энэ хуулийн 7.1-д заасан баримт бичгийг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настанд, хувийн хэвшлийн байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настанд харьяалах аймаг, нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь тус тус нэмэгдлийг сар бүр, нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хөнгөлөлтийг тухай бүр ахмад настны арилжааны банкин дахь нэрийн дансанд шилжүүлнэ.” гэсэн хэсэг нэмсэн.

## **13. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Нийгмийн халамжийн сангаас үзүүлж байгаа үйлчилгээнүүд нь тогтоосон жишиг үнэтэй байдаг бөгөөд холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас үйлчилгээг хүргэх нөхцөл шалгуур, журмыг баталсан байдаг.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүчирхийлэлд өртсөн хүн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд нийгмийн үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдтэй 3 хүртэл жилийн хугацаанд шууд гэрээ байгуулахаар тусгасан.

## **14. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай**

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний биометрийн мэдээллийг ашиглах боломжгүй байдаг.

Нийгмийн халамжийн цахим системийг хөгжүүлэн ашиглаж байгаа ч цахим системд бүртгэгдсэн гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгох,

үйлчилгээний давхардлыг арилгах, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зөрчлийг арилгах зэрэгт биометрийн мэдээллийг ашиглах зайлшгүй шаардлагатай байна.

Иймд тус хуульд “10.1.6.төрөөс үзүүлж байгаа эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний бүртгэл, мэдээллийг цахимжуулах, үйлчилгээний давхардлыг арилгах, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зөрчлийг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгох зорилгоор биометрийн мэдээллийг.” гэсэн заалт нэмэхээр боловсруулсан.

--oOo--